**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2020 оны 05 сарын 13 өдөр　　　　Дугаар А/289　　　　Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.9 дэх заалт, Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах комиссын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03 дугаар тэмдэглэл, 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тэмдэглэл, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцсэн 5 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД　　　　Д.САРАНГЭРЭЛ

141201076

Эрүүл мэндийн сайдын
2020 оны .05 сарын 13-ны өдрийн
А/289 дугаар тушаалын хавсралт

# МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТАД ТЭНЦСЭН ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

| № | Овог нэр | Харъяалал | Монгол Улсад ажиллах байгууллага | Хамтран ажиллах гадаадын байгууллага | Гэрчилгээний сери/дугаар | Төрөлжсөн мэргэшлийн чиглэл | Зөвшөөрлийн төрөл | Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Пак Кван Тэ<br>Park Kwan Tae | Бүгд Найрамдах Солонгос Улс | “Ач тус хоспис” ХХК-ний Агапе хоспис | - | ГЭ0002525 | Ерөнхий мэс засал судлал | Эмчлэх | 1 жил |
| 2. | Хён Сил Ги<br>Hyeon Seulgi | Бүгд Найрамдах Солонгос Улс | “Ач тус хоспис” ХХК-ний Агапе хоспис | - | ГЭ0002526 | Ерөнхий мэс засал судлал | Эмчлэх | 1 жил |
| 3. | Хасбагана<br>Hasibagen | Бүгд Найрамдах Хятад Ард Улс | “Мандарваасайхан” ХХК-ний “Наранмандал” эмнэлэг | - | ГЭ0002527 | Уламжлалт анагаах ухаан судлал | Эмчлэх | 1 жил |
| 4. | Оюундалай<br>Wuyundalai | Бүгд Найрамдах Хятад Ард Улс | “Уран Дөш Сервис” ХХК-ний “Мандал” эмнэлэг | - | ГЭ0002528 | Сэргээн засал судлал | Эмчлэх | 1 жил |
| 5. | Фонтал Гиронза Жулие Анна<br>Fontal Gironza Julie Anna | Бүгд Найрамдах Колумб Улс | “Интернейшнл СОС Монголиа лимитед” ХХК-ний эмнэлэг | - | ГЭ0002529 | Яаралтай тусламж судлал | Эмчлэх | 2020.09.22 хүртэл |